



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас: 261828 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ
ТАНАА

2022 02 25 № 07/403
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52,094,978,490.37</u>	<u>45,554,588,086.97</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,588,775,186.75	2,001,985,865.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,588,775,186.75	2,001,985,865.49
3121	Төгрөг	1,588,775,186.75	2,001,985,865.49
31211	Төрийн сангийн харилцах	1,588,754,005.75	2,001,964,684.49
31213	Арилжааны банк дахь харилцах	21,181.00	21,181.00
33	АВЛАГА	-	2,042,762.86
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,400,000.00
335	Бусад авлага	-	642,762.86
3351	Байгууллагаас авах авлага	-	642,762.86
35	БАРАА МАТЕРИАЛ	7,038,561.89	17,551,671.89
354	Хангамжийн материал	7,038,561.89	17,551,671.89
35410	Бичиг хэргийн материал	524,799.89	1,982,249.89
35420	Аж ахуйн материал	4,928,762.00	15,096,422.00
35440	Түлш, шатах тослох материал	-	473,000.00
35450	Барилгын засварын материал	145,000.00	-
35460	Хүнсний материал	1,440,000.00	-
36	НӨӨЦИЙН БАРАА	50,499,164,741.73	43,533,007,786.73
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	50,499,164,741.73	43,533,007,786.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>903,743,593.98</u>	<u>1,359,298,275.53</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	903,743,593.98	1,359,298,275.53
392	Биет хөрөнгө	879,789,228.61	728,652,983.86
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	977,481,262.66	1,119,142,492.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	(127,834,415.78)	(411,409,349.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,396,664.81	51,839,064.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,254,283.08)	(30,919,223.74)
393	Биет бус хөрөнгө	23,954,365.37	630,645,291.67
39301	Програм хангамж	-	5,940,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(792,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	54,591,524.01	697,525,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(30,637,158.64)	(72,027,708.33)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>52,998,722,084.35</u>	<u>46,913,886,362.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,588,754,005.75</u>	<u>2,001,964,684.49</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,588,754,005.75	2,001,964,684.49
413	Өглөг	1,588,754,005.75	2,001,964,684.49
4136	Бусад өглөг	1,588,754,005.75	2,001,964,684.49
41361	Байгууллагад төлөх өглөг	1,588,754,005.75	2,001,964,684.49
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>51,409,968,078.60</u>	<u>44,911,921,678.01</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	51,409,968,078.60	44,911,921,678.01
511	Засгийн газрын оруулсан капитал	297,274,203.04	297,274,203.04
51101	Өмч: - төрийн	297,274,203.04	297,274,203.04
512	Хуримтлагдсан үр дүн	51,100,812,803.57	44,596,678,902.98
51210	Өмнөх үеийн үр дүн	51,100,812,803.57	40,270,556,772.57
51220	Тайлант үеийн үр дүн	-	4,326,122,130.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,881,071.99	17,968,571.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>52,998,722,084.35</u>	<u>46,913,886,362.50</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	25,091,406,367.52	13,237,492,726.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,531,078.76	60,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,531,078.76	60,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,993,964.66	60,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	60,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,993,964.66	00.00
120009	Бусад орлого	2,537,114.10	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,071,875,288.76	13,237,432,726.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	25,071,875,288.76	13,237,432,726.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,929,432,000.00	9,373,333,650.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	15,142,443,288.76	3,864,099,076.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,782,833,607.64	8,911,370,595.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,782,833,607.64	8,911,370,595.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,074,980,151.54	2,031,931,133.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,803,200.00	497,220,946.95
210101	Үндсэн цалин	424,909,500.00	363,905,169.64
210102	Нэмэгдэл	96,554,700.00	80,429,501.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,339,000.00	52,886,275.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,628,300.00	68,833,584.79
210201	Тэтгэврийн даатгал	74,628,300.00	48,140,773.33
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	5,500,193.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	4,051,364.73
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,012,841.03
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	10,128,411.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,397,700.00	25,237,776.00
210301	Гэрэл цахилгааны зардал	18,145,000.00	15,632,700.00
210302	Түлш, халаалтын зардал	5,331,700.00	8,374,876.00
210303	Цэвэр, бохир усны зардал	4,921,000.00	1,230,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,315,177.00	66,774,494.25
210401	Бичиг хэрэг	5,686,375.00	5,850,281.93
210402	Тээвэр, шатахуун	4,804,000.00	2,793,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,759,600.00	12,277,287.08
210404	Ном, хэвлэл	15,000,000.00	14,883,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,065,202.00	30,970,425.24
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,353,387.00	38,410,840.00
210601	Багаж хэрэгсэл	00.00	1,719,500.00
210604	Урсгал засвар	45,353,387.00	36,691,340.00
2107	Томилолт, зочны зардал	11,911,000.00	307,000.00
210702	Дотоод албан томилолт	11,911,000.00	00.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	307,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,514,567.00	42,780,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,436,800.00	41,030,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	4,900,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	77,220.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,547.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,900,000.00	1,750,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,181,056,820.54	1,292,365,991.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,033,956,123.00	909,346,142.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,045,000.00	3,340,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,055,697.54	379,679,848.45

25	ТАТААС	4,773,789,500.00	5,385,022,000.00
2501	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,429,952,000.00	5,109,952,000.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,429,952,000.00	5,109,952,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	343,837,500.00	275,070,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	343,837,500.00	275,070,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,934,063,956.10	1,494,417,462.51
	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,413,129,684.80	1,317,206,416.18
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,413,129,684.80	1,317,206,416.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,246,800.00	69,532,967.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	26,800,000.00	31,132,967.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамгуулал	00.00	38,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,446,800.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	469,687,471.30	107,678,079.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	469,687,471.30	107,678,079.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,308,572,759.88	4,326,122,130.41
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	92,095,322.40	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	92,095,322.40	00.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(92,095,322.40)	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,216,477,437.48	4,326,122,130.41

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	32,900,835,792.84	33,209,991,067.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,983,499,573.25	1,983,499,573.25
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	34,884,335,366.09	35,193,490,641.12
Тайлант үеийн үр дүн	-	-	16,216,477,437.48	16,216,477,437.48
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	51,100,812,803.57	51,409,968,078.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(10,830,256,031.00)	(10,830,256,031.00)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	40,270,556,772.57	40,579,712,047.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	6,087,500.00	-	6,087,500.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	4,326,122,130.41	4,326,122,130.41
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	297,274,203.04	17,968,571.99	44,596,678,902.98	44,911,921,678.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	25,074,412,402.86	14,614,441,400.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,537,114.10	1,377,008,674.24
120	Нийтлэг татварын бус орлого	2,537,114.10	1,377,008,674.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,537,114.10	1,377,008,674.24
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	60,000.00
120009	Бусад орлого	2,537,114.10	1,376,948,674.24
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,071,875,288.76	13,237,432,726.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	25,071,875,288.76	13,237,432,726.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,929,432,000.00	9,373,333,650.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	15,142,443,288.76	3,864,099,076.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,931,947,933.10	9,373,393,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,931,947,933.10	9,373,393,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,224,094,477.00	2,493,954,187.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,803,200.00	497,220,946.95
210101	Үндсэн цалин	424,909,500.00	363,905,169.64
210102	Нэмэгдэл	96,554,700.00	80,429,501.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,339,000.00	52,886,275.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,628,300.00	68,833,584.79
210201	Тэтгэврийн даатгал	74,628,300.00	48,140,773.33
210202	Тэтгэмжийн даатгал	-	5,500,193.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4,051,364.73
210204	Ажилгүйдлийн даатгал	-	1,012,841.03
210205	Эрүүл мэндийн даатгал	-	10,128,411.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,397,700.00	25,237,776.00
210301	Гэрэл цахилгааны зардал	18,145,000.00	15,632,700.00
210302	Түлш, халаалтын зардал	5,331,700.00	8,374,876.00
210303	Цэвэр, бохир усны зардал	4,921,000.00	1,230,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,370,000.00	64,519,535.21
210401	Бичиг хэрэг	3,733,900.00	7,313,899.00
210402	Тээвэр, шатахуун	4,804,000.00	3,266,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,759,600.00	12,277,287.08
210404	Ном, хэвлэл	15,000,000.00	14,883,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	38,072,500.00	26,778,849.13
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	175,743,703.00	170,020,770.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,390,316.00	133,329,430.00
210604	Урсгал засвар	45,353,387.00	36,691,340.00
2107	Томилолт, зочны зардал	13,026,000.00	307,000.00
210702	Дотоод албан томилолт	11,911,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,115,000.00	307,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,514,567.00	48,720,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,436,800.00	41,030,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,900,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	77,220.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,547.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,900,000.00	7,690,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,205,611,007.00	1,619,094,074.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,184,566,007.00	1,615,754,074.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,045,000.00	3,340,000.00
	ТАТААС	4,773,789,500.00	5,385,022,000.00
	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,429,952,000.00	5,109,952,000.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	4,429,952,000.00	5,109,952,000.00
	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	343,837,500.00	275,070,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	343,837,500.00	275,070,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,934,063,956.10	1,494,417,462.51
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,413,129,684.80	1,317,206,416.18
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,413,129,684.80	1,317,206,416.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,246,800.00	69,532,967.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	26,800,000.00	31,132,967.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	38,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,446,800.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	469,687,471.30	107,678,079.33
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	469,687,471.30	107,678,079.33
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>15,142,464,469.76</u>	<u>5,241,047,750.24</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,222,834,315.76	4,827,837,071.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,222,834,315.76	4,827,837,071.50
2200	Дотоод эх үүсвэрээр	14,222,834,315.76	4,827,837,071.50
220001	Барилга байгууламж	666,648,937.00	2,169,461,984.00
222001	Тоног төхөөрөмж	13,556,185,378.76	1,839,366,912.00
223001	Бусад хөрөнгө	-	819,008,175.50
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(14,222,834,315.76)</u>	<u>(4,827,837,071.50)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	919,630,154.00	413,210,678.74
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	669,145,032.75	1,588,775,186.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,588,775,186.75	2,001,985,865.49

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,319,343,500.00	9,265,715,570.67	2,053,627,929.33	81.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,319,343,500.00	9,265,715,570.67	2,053,627,929.33	81.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,547,326,400.00	2,493,954,187.49	2,053,372,212.51	54.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	552,803,200.00	497,220,946.95	55,582,253.05	89.9
210101	Үндсэн цалин	424,909,500.00	363,905,169.64	61,004,330.36	85.6
210102	Нэмэгдэл	96,554,700.00	80,429,501.92	16,125,198.08	83.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,339,000.00	52,886,275.39	(21,547,275.39)	168.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,628,400.00	68,833,584.79	5,794,815.21	92.2
210201	Тэтгэврийн даатгал	52,516,300.00	48,140,773.33	4,375,526.67	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	5,528,000.00	5,500,193.90	27,806.10	99.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,422,400.00	4,051,364.73	371,035.27	91.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,105,600.00	1,012,841.03	92,758.97	91.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,056,100.00	10,128,411.80	927,688.20	91.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,614,000.00	25,237,776.00	4,376,224.00	85.2
210301	Гэрэл, цахилгаан	15,632,700.00	15,632,700.00	-	100.0
210302	Түлш, халаалт	9,798,500.00	8,374,876.00	1,423,624.00	85.5
210303	Цэвэр, бохир ус	4,182,800.00	1,230,200.00	2,952,600.00	29.4
2104	Хангамж, бараа материалын зардал	67,672,800.00	64,519,535.21	3,153,264.79	95.3
210401	Бичиг хэрэг	8,236,100.00	7,313,899.00	922,201.00	88.8
210402	Тээвэр, шатахуун	3,539,200.00	3,266,000.00	273,200.00	92.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,625,000.00	12,277,287.08	1,347,712.92	90.1
210404	Ном, хэвлэл	15,000,000.00	14,883,500.00	116,500.00	99.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,272,500.00	26,778,849.13	493,650.87	98.2
2105	Нормативт зардал	150,000.00	-	150,000.00	00.0
210501	Нормын хувцас зөөлөн эдлэл	150,000.00	-	150,000.00	00.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,082,700.00	170,020,770.00	1,061,930.00	99.4
210601	Багаж, техник хэрэгсэл	134,000,000.00	133,329,430.00	670,570.00	99.5
210604	Урсгал засвар	37,082,700.00	36,691,340.00	391,360.00	98.9
2107	Томилолт, зочны зардал	4,886,300.00	307,000.00	4,579,300.00	06.3
210702	Дотоод албан томилолт	3,944,300.00	-	3,944,300.00	00.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	942,000.00	307,000.00	635,000.00	32.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,067,700.00	48,720,500.00	11,347,200.00	81.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	44,323,000.00	41,030,000.00	3,293,000.00	92.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	-	5,000,000.00	00.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,022,700.00	-	1,022,700.00	00.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	-	300,000.00	00.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-	22,000.00	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,400,000.00	7,690,500.00	1,709,500.00	81.8

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,586,421,300.00	1,619,094,074.54	1,967,327,225.46	45.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,576,585,300.00	1,615,754,074.54	1,960,831,225.46	45.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,836,000.00	3,340,000.00	6,496,000.00	34.0
	ТАТААС	5,385,022,000.00	5,385,022,000.00	-	100.0
	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,109,952,000.00	5,109,952,000.00	-	100.0
	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	5,109,952,000.00	5,109,952,000.00	-	100.0
	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	275,070,000.00	275,070,000.00	-	100.0
	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	275,070,000.00	275,070,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,386,995,100.00	1,386,739,383.18	255,716.82	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,317,207,500.00	1,317,206,416.18	1,083.82	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,317,207,500.00	1,317,206,416.18	1,083.82	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,787,600.00	69,532,967.00	254,633.00	99.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,387,600.00	31,132,967.00	254,633.00	99.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,400,000.00	38,400,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,319,343,500.00	9,265,715,570.67	2,053,627,929.33	81.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,319,343,500.00	9,265,715,570.67	2,053,627,929.33	81.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	11,319,343,500.00	9,265,715,570.67	2,053,627,929.33	81.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,588,775,186.75	(1,588,775,186.75)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,001,985,865.49	(2,001,985,865.49)	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	37	37	00	100
620001	Удирдах ажилтан	1	1	0	100
620002	Гүйцэтгэх ажилтан	34	34	0	100
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх, бараа материалын орлого, зарлага гаргахдаа анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах, цаг бүртгэлийн хуудсыг үнэн зөв бөглөж, албан хаагчдын цалин хөлсийг алдаагүй бодож байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 10-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор С.Алтанхуяг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа хэрэгжүүлсэн.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Монгол Улсын цахим хөгжил, харилцаа холбоо, мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал, сансрын технологи, өргөн нэвтрүүлгийн талаарх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлого, стратегийн төлөвлөлтийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулж, баталгаажуулсан байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар дотоод хяналтын нэгжгүй боловч төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан*

гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасан хяналтын үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тус байгууллагын дотоод аудитын чиг үүргийг ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хэрэгжүүлдэг боловч тайлант жил аудит хийгдээгүй тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 52,998,722.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 794,980.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 596,235.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,084,835.7 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,588,775.2	2,001,985.9	413,210.7
Авлага	-	2,042.7	2,042.7
Бараа материал	7,038.6	17,551.7	10,513.1
Бусад эргэлтийн хөрөнгө	50,499,164.7	43,533,007.8	(6,966,156.9)
Үндсэн хөрөнгө	903,743.6	1,359,298.3	455,554.7
Нийт хөрөнгө	52,998,722.1	46,913,886.4	(6,084,835.7)
Өр төлбөр	1,588,754.0	2,001,964.7	413,210.7
Засгийн газрын хувь оролцоо	51,409,968.1	44,911,921.7	(6,498,046.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	52,998,722.1	46,913,886.4	(6,084,835.7)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Тайлант онд Засгийн газрын 397 дугаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу хэрэгжсэн хөрөнгө оруулалтын гэрээний барьцаа хөрөнгө байршуулснаас шалтгаалан мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн дансны үлдэгдэл оны эхнээс 413,210.7 мянган төгрөгөөр тус тус өссөн;
- Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт болон иргэдэд төрөл бүрийн мэдэгдэл, мэдээлэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлэх хоёр төслийн хүрээнд биет бус хөрөнгө худалдан авсан нь үндсэн хөрөнгийн өсөлтөд голлон нөлөөлсөн;
- Бусад эргэлтийн хөрөнгө болон засгийн газрын хувь оролцоо дансны бууралт нь өмнө жилүүдэд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон 10,726,099.0 мянган төгрөгийн хаагдаагүй зардлыг ТӨБЗГ-ын 2021 оны 144 дүгээр тогтоолын дагуу зарлагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Төсөв байгууллагын өөрийн орлого	16,994.0	60.0	(16,934.0)
Бусад орлого	2,537.1	00.0	(2,537.1)
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,929,432.0	9,373,333.6	(556,098.4)
Хөрөнгийн санхүүжилт	15,142,443.3	3,864,099.1	(11,278,344.2)
Үйл ажиллагааны орлого	25,091,406.4	13,237,492.7	(11,853,913.7)
Бараа, ажил үйлчилгээний зардал	2,074,980.1	2,031,931.1	(43,049.0)
Татаас	4,773,789.5	5,385,022.0	611,232.5
Урсгал шилжүүлэг	1,934,064.0	1,494,417.5	(439,646.5)
Үйл ажиллагааны зардал	8,782,833.6	8,911,370.6	128,537.0
Үйл ажиллагааны бус зардал	92,095.3	00.0	(92,095.3)

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого 11,853,913.7 мянган төгрөгөөр буурсан нь тус онд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан өмнө жилээс цөөн тооны төсөл хөтөлбөр хэрэгжиж, хөрөнгийн санхүүжилт буурсантай холбоотой байна.

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын өсөлтөд Радио телевизийн үндэсний сүлжээ ТӨҮГ-т радио телевизийн нэвтрүүлгийг технологийн горимын өндөр түвшинд дамжуулах, сүлжээний техникийн найдвартай ажиллагааг хангах, шинэ техник технологи нэвтрүүлэх үйл ажиллагаанд зориулан төрөөс олгодог санхүүжилт өмнөх оноос 680,000.0 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 11,779,994.1 мянган төгрөг, үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 5,008,232.7 мянган төгрөг, татаас санхүүжилтэд 5,385,022.0 төгрөг, засгийн газрын урсгал шилжүүлэг 1,386,739.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас Монгол Улсын гадаад өр, зээлийн таазтай уялдуулан Улсын төсвийн санхүүжилтийг 261,821.9 мянган төгрөгөөр бууруулж 11,518,172.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,319,343.5 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар 3,864,099.1 мянган төгрөг, нийт 15,183,442.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 15,183,442.5 мянган төгрөгийн санхүүжилтээс 13,129,814.7 мянган төгрөгийг зарцуулж, 86.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу үндсэн үйл ажиллагааны зардлаас 18.1 хувийг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71302	Мэдээллийн нэгдсэн тогтолцоо	11,319,343.5	9,265,715.6	2,053,627.9	81.9%
2	70103	Засаглалын ерөнхий удирдлага	3,864,099.1	3,864,099.1	0	100%
Нийт дүн			15,183,442.6	13,129,814.7	2,053,627.9	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монгол улсын засгийн газрын бүтцийн тухай хуулийн 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулж, Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 14 дүгээр “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрыг татан буулгасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 23,220,759.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй асуудлаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт 46 хувьтай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 2021 онд нийт 23,445,578.6 мянган төгрөгийн 200 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5,406,916.1 мянган төгрөгийн 14 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 85.7 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	7,285.0	1	7,285.0	-	-	100.0
Албан шаардлага	3	24,926,445.1	2	12,431,784.8	1	10,726,099.0	66.7
Зөвлөмж	3	1,054,236.0	3	1,054,236.0	-	-	100.0
Нийт дүн	7	25,987,966.1	6	13,493,305.8	1	10,726,099.0	85.7

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон 23,220,759.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй зөрчилд өгсөн 1 албан шаардлагын биелэлт 46 хувь, бусад нийт 2,767,206.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,224,855.8 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 5,179,188.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 6,087.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 39,580.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 6 алдаа, зөрчлийн дүн 45,667.8 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 794,980.8 мянган төгрөгөөс бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Үйл ажиллагааны орлогыг 5,148,352.0 мянган, нийт зарлагыг 5,164,145.0 мянган төгрөгөөр дутуу, хангамжийн материалыг 15,043.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлснийг аудитын явцад залруулав.

4.2 Албан шаардлага

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 20 арга хэмжээний үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлаар Төрийн өмчийн бодлого зохицуулах газарт албан бичгээр хүргүүлсэн боловч эцэслэн шийдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.4 “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

2. Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 12 нэр төрлийн 6,087.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг дахин үнэлж, бүртгэлд тусгасан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1 “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар шийдвэр гаргуулах талаар албан шаардлага өгөв.

3. Тус байгууллагын бараа материалын орлого, зарлагад ерөнхий нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах талаар албан шаардлага өгөв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүйгээс 2,042.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. **Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 34,915.6 мянган төгрөгийн бараа материалын зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Илрүүлэлт:

Цагийн бүртгэлийг бодит ажилласан цагаас зөрүүтэй тусгаснаас цалингийн зардлыг 2,621.9 мянган төгрөгөөр илүү тооцоолсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Ерөнхий нягтлан бодогч цалин, олговрыг тооцоолохоос өмнө цагийн бүртгэл дэх мэдээлэл үнэн зөв эсэхэд хяналт хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Үйл ажиллагааны орлогыг 5,148,352.0 мянга, нийт зарлагыг 5,164,145.0 мянган төгрөгөөр дутуу, хангамжийн материалыг 15,043.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна.	Залруулга хийв	1	5,179,188.0	1	5,179,188.0						
2	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 20 арга хэмжээний үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудал эцэслэн шийдэгдээгүй байна.	Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх	1	-					1	-		
3	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 12 нэр төрлийн 6,087.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг дахин үнэлж, бүртгэлд тусгасан байна.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар шийдвэр гаргуулах	1	6,087.5					1	6,087.5		
4	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Төсвийг зохистой удирдаагүйгээс 2,042.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, төсвийг зохистой удирдаж өр, авлага үүсгэхгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	2,042.8							1	2,042.8

5	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Анхан шатны баримтын бүрдэл дутуу 34,915.6 мянган төгрөгийн бараа материалын зардал байна.	Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	34,915.6							1	34,915.6
6	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Цагийн бүртгэлийг бодит ажилласан цагаас зөрүүтэй тусгаснаас цалингийн зардлыг 2,621.9 мянган төгрөгөөр илүү тооцоолсон байна.	Ерөнхий нягтлан бодогч цалин, олговрыг тооцоолохоос өмнө цагийн бүртгэл дэх мэдээлэл үнэн зөв эсэхэд хяналт хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	2,621.9							1	2,621.9
7	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Тус байгууллагын бараа материалын орлого, зарлагад ерөнхий нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй байна	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах	1						1			
Дүн					7	5,224,855.8	1	5,179,188.0			3	6,087.5	3	39,580.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал														
1	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	АХГ-2022/138/НА-СТА-ТШЗ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар 2021 онд нийт 23,445,578.6 мянган төгрөгийн 200 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 5,406,916.1 мянган төгрөгийн 14 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна	Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх	1	5,406,916.1							1	5,406,916.1
Дүн					1	5,406,916.1							1	5,406,916.1
Нийт дүн					8	10,631,771.9	1	5,179,188.0			3	6,087.5	4	5,446,496.4



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 76/АД 160056
АХТ-2022/138/АА-СТА-ТМ? Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын бараа материалын орлого, зарлагад ерөнхий нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, мэдээллийн технологийн яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-85.Docx

С010800281



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 77/А0160056
АХГ-2022/138/АА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 12 нэр төрлийн 6,087,500.00 төгрөгийн тоног төхөөрөмжийг дахин үнэлж, бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар шийдвэр гаргуулах, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, мэдээллийн технологийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засагийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
90 10.10.10.201\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-86.Docx

С010800284



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 78/А0160056
АХС - 2022 /138/НА - СТА - ГИМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 20 арга хэмжээний үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх асуудлаар Төрийн өмчийн бодлого зохицуулах газарт албан бичгээр хүргүүлсэн боловч эцэслэн шийдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.4 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ашиглагч байгууллагуудад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэж, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цахим хөгжил, мэдээллийн технологийн яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Болор-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-87.Docx

5019120396

0010800287

